

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024 /250/ НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭСАНТ СУМЫН БОЛОРХОН
ЦЭЦЭРЛЭГИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер: О.Амаржаргал

Утас: 70273463. Цахим хаяг: amarjargal@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Голден пэйж Аудит" ХХК

Гүйцэтгэх захирал: С.Оюунгэрэл

Утас: 99170900 Цахим хаяг: info@goldenpageaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/90.
таний _____-ны № _____-т

**ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭСАНТ
СУМЫН БОЛОРХОН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Л.СЭЛЭНГЭ ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Эрдэнэсант сумын Болорхон хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Эрдэнэсант сумын Болорхон хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх болсноор жилийн эцэст зарцуулагдаагүй мөнгөн хөрөнгийг дараагийн жилд зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 68,684.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Эрдэнэсант сумын Болорхон хүүхдийн цэцэрлэг "Сургуулийн өмнөх боловсролыг хүүхдийн төлөвшил, хөгжлийн суурь үе хэмээн үзэж, цэцэрлэгийн үйлчилгээний болон сургалтын чанарыг сайжруулахад чиглэсэн цогц үйл ажиллагааг зохион байгуулна" гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Төв аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын даргаар батлуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 зорилтын хүрээнд 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 91,0 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	45,087,664.40	83,014,239.17
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	40,053,314.40	68,684,079.17
312	Банканд байгаа бэлэн мөнгө	40,053,314.40	68,684,079.17
3121	Төгрөг	40,053,314.40	68,684,079.17
31211	Төрийн сангийн харилцах	40,053,314.40	68,684,079.17
35	БАРАА МАТЕРИАЛ	5,034,350.00	14,330,160.00
351	Түүхий эд материал	4,776,750.00	13,956,360.00
35110	Тусгай зориулалттай материал	4,776,750.00	13,956,360.00
354	Хангамжийн материал	257,600.00	373,800.00
35460	Хүнсний материал	257,600.00	373,800.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,482,061.67	1,081,887,369.10
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,482,061.67	1,081,887,369.10
392	Биет хөрөнгө	7,482,061.67	1,081,887,369.10
39201	Барилга, байгууламж, орон сууц	00.00	1,045,170,119.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-4,354,875.51
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	7,569,400.00	25,682,375.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-187,838.33	-3,566,985.11
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	100,500.00	20,747,330.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-1,790,594.28
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	52,569,726.07	1,164,901,608.27
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	52,569,726.07	1,164,901,608.27
51	Засгийн газрын хувь оролцоо	52,569,726.07	1,164,901,608.27
512	Хуримтлагдсан үр дүн	52,569,726.07	1,164,901,608.27
51210	Өмнөх үеийн үр дүн	52,569,726.07	52,569,726.07
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	1,112,331,882.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	52,569,726.07	1,164,901,608.27

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	244,764,950.00	1,488,693,134.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	244,764,950.00	1,090,053,834.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,521,350.00	1,090,053,834.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,521,350.00	1,090,053,834.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6,521,350.00	1,090,053,834.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	238,243,600.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	00.00	398,639,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	39,615,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	39,615,800.00
1330	Төсвийн захирагчдаас	00.00	359,023,500.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	359,023,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	192,195,223.93	376,361,251.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	192,195,223.93	376,361,251.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	184,087,223.93	374,612,508.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	129,482,975.52	241,998,163.73
210101	Үндсэн цалин	104,815,088.61	174,736,915.58
210102	Нэмэгдэл	17,499,342.22	55,632,853.33
210104	Урамшуулал	7,168,544.69	11,628,394.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,039,430.08	29,714,993.50
210201	Тэтгэврийн даатгал	12,549,347.11	20,240,026.28
210202	Тэтгэмжийн даатгал	1,152,692.39	2,341,180.65
210203	ҮОМШӨ-ний даатгал	922,153.82	1,904,943.86
210204	Ажилгүйдлийн даатгал	224,785.28	466,753.37
210205	Эрүүл мэндийн даатгал	3,190,451.48	4,762,089.34
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	00.00	37,367,056.69
210301	Гэрэл, цахилгаан	00.00	4,176,656.69
210302	Түлш, халаалт	00.00	32,599,200.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	591,200.00
2105	Нормативт зардал	26,658,155.00	43,696,500.00
210502	Хоол, хүнс	26,658,155.00	43,696,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	592,000.00	832,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	592,000.00	832,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,314,663.33	20,503,594.57
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,218,275.00	9,333,178.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,908,550.00	1,645,800.00
210903	үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	187,838.33	9,524,616.57
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,108,000.00	1,748,743.31
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,108,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	1,748,743.31
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	52,569,726.07	1,112,331,882.20
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	52,569,726.07	1,112,331,882.20

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	238,243,600.00	398,639,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	238,243,600.00	00.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	238,243,600.00	00.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	238,243,600.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	00.00	398,639,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	39,615,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	39,615,800.00
1330	Төсвийн захирагчдаас	00.00	359,023,500.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	359,023,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	198,190,285.60	368,259,791.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	198,190,285.60	368,259,791.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	190,082,285.60	368,259,791.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	129,482,965.53	241,998,163.73
210101	Үндсэн цалин	104,815,088.61	174,736,915.58
210102	Нэмэгдэл	17,499,342.22	55,632,853.33
210104	Урамшуулал	7,168,534.70	11,628,394.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,039,440.07	29,714,993.50
210201	Тэтгэврийн даатгал	12,549,347.12	20,240,026.28
210202	Тэтгэмжийн даатгал	1,152,692.39	2,341,180.65
210203	ҮОМШӨ-ний даатгал	922,153.82	1,904,943.86
210204	Ажилгүйдлийн даатгал	224,795.27	466,753.37
210205	Эрүүл мэндийн даатгал	3,190,451.47	4,762,089.34
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	00.00	37,367,056.69
210301	Гэрэл, цахилгаан	00.00	4,176,656.69
210302	Түлш, халаалт	00.00	32,599,200.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	591,200.00
2105	Нормативд зардал	26,915,755.00	43,888,800.00
210502	Хоол, хүнс	26,915,755.00	43,888,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	500,000.00
210604	Урсгал засвар	00.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	592,000.00	832,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	592,000.00	832,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,052,125.00	13,958,578.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,852,175.00	11,461,978.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,199,950.00	2,496,600.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,108,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,108,000.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	40,053,314.40	30,379,508.08
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	40,053,314.40	30,379,508.08
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	40,053,314.40
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	40,053,314.40	68,684,079.17

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	408,170.00	00.00	00.00	408,170.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	408,170.00	00.00	00.00	408,170.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	52,161,556.07	52,161,556.07
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	408,170.00	00.00	52,161,556.07	52,569,726.07
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,112,331,882.20	1,112,331,882.20
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	408,170.00	00.00	1,164,493,438.27	1,164,901,608.27

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	438,692,200.00	370,008,535.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	438,692,200.00	370,008,535.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	438,692,200.00	370,008,535.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	298,358,900.00	241,998,163.73
210101	Үндсэн цалин	199,281,100.00	174,736,915.58
210102	Нэмэгдэл	89,879,200.00	55,632,853.33
210104	Урамшуулал	9,198,600.00	11,628,394.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,294,500.00	29,714,993.50
210201	Тэтгэврийн даатгал	25,360,200.00	20,240,026.28
210202	Тэтгэмжийн даатгал	2,983,500.00	2,341,180.65
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,386,800.00	1,904,943.86
210204	Ажилгүйдлийн даатгал	596,800.00	466,753.37
210205	Эрүүл мэндийн даатгал	5,967,200.00	4,762,089.34
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,115,800.00	37,367,056.69
210301	Гэрэл, цахилгаан	7,325,800.00	4,176,656.69
210302	Түлш, халаалт	30,690,000.00	32,599,200.00
210303	Цэвэр, бохир ус	1,100,000.00	591,200.00
2105	Нормативд зардал	48,630,700.00	43,888,800.00
210502	Хоол, хүнс	48,630,700.00	43,888,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00

210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	832,200.00	832,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	832,200.00	832,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,960,100.00	13,958,578.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,463,500.00	11,461,978.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,496,600.00	2,496,600.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	399,076,400.00	399,076,814.40
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	359,023,500.00	359,023,500.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	359,023,500.00	359,023,500.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	39,615,800.00	39,615,800.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	40,053,314.40
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	68,684,079.17
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	16	16
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	15	15

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 9,562.8 мянган төгрөгийн зөрчил 2 илэрснээс 9,562.8 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлэв 1 зөвлөмж өглөө.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.2 Албан шаардлага

1. Илрүүлэлт: Мөнгөн хөрөнгийн горим сорил хэрэгжүүлэхэд үйл ажиллагааны зардал, бараа түүхий эд, материал худалдан авах анхан шатны цахим баримтын бүрдэлд илүү 4,395.0 мянган төгрөг, дутуу 5,167.8 мянган төгрөг нийт 9,562.8 мянган төгрөгийг баримтжуулаагүй бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянан, баталгаажуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн оршин байх, тохиолдсон байх, үнэлгээ, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь. МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.8-д “байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй”; 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Илрүүлэлт: Худалдан авалт хийхдээ үнийн харьцуулалт хийгээгүй, гэрээ байгуулаагүй, ил тод байх, мэдээлэл авах эрхийг хангаж ажиллаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50 дугаар

зүйлийн 50.1-д “Худалдан авах ажиллагаанд төлөвлөх, бэлтгэх, хэрэгжүүлэх, хяналт тавих болон бусад үүрэгтэй оролцож байгаа төрийн албан хаагч дараах үүрэг хүлээнэ”, 50.1.1-д “шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх”, 50.1.2-д “төрийн ашиг сонирхлыг дээдлэх” гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь. МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх , төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.8-д “байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй”; 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

5.3.1 Албан хэрэг хөтлөлтийн талаар

1. Илрүүлэлт: Төсвийн захирагч нь эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэж, сум орон нутгийн боловсролын сургалтын байгууллагыг захиргааны болон мэргэжлийн удирдлагаар ханган, хууль тогтоомж, захиргааны шийдвэрийг хэрэгжүүлж, хугацаанд нь тайлагнах, удирдах ажилтны ёс зүй, манлайлал шуурхай байдлыг эрхэмлэн ажиллах үүрэг хүлээсэн. Аудитад үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл, үр дүнгийн хэрэгжилтийн талаар тайлан, санхүүгийн тодруулга тайлан ирүүлээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”

8.1.5.санхүүгийн тайлангийн тодруулга бэлтгэдэг байх, гэснийг баримтлан ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан хэргийн стандартыг мөрдөн ажиллах зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 02 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Цахим баримт илүү	1	4,395.0			1	4,395.0							

Худалдан авах ажиллагаа дутуу	1	5167,8			1	5167,8				
Бичиг хэрэг хөтлөлт	1						1			
Дүн	3	9562,8			2	9562,8	1			

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

